


Num.edu.mn цахим шуудангийн хаяг шинээр нээлгэх болон сэргээх, цахим шуудангийн хаяг бүртгүүлэх заавар

1. Сиси системд өөрийн эрхээр нэвтрэнэ. /Хэрэв та Сиси системд нэвтрэх эрхгүй бол Бичиг хэрэг, Хүний нөөцийн ажилтнаас авна уу.



МОНГОЛ УДСБН
1942
ИХ СУРГУУЛЬ

SISi мэдээллийн систем 4.0

Хэрэглэгчийн нэр / Username

Нууц үг / Password

ftk

Дээрх кодыг оруулна уу / Enter code

Нууц үгээ мартсан уу? / Forgot Password?

Нэвтрэх / Sign in

2. Зүүн гар талд байрлах “Цахим шуудан” цэсрүү орно уу. Энд таны бүртгэлтэй цахим шуудангийн хаягууд байна. Эндээс МУИС-д хамаарах цахим шуудангийн хаягийнхаа нууц үгийг солих боломжтой бөгөөд харгалзах хаягны хойно байрлах “Нууц үг сэргээх” гэсэн товчийг дарж шинэ нууц үгээ оруулна.

Анхаар: Солигдсон тухай мэдээлэл гарч ирснээс хойш хэсэг хугацааны дараа таны нууц үг солигдохыг анхаарч хүлээцтэй хандана уу.

Бүртгэлтэй цахим шуудангийн хаягууд	
Цахим шуудангийн хаягууд	
utziibaatar66@gmail.com	
utziibaatar@num.edu.mn	Нууц үг сэргээх

3. Хэрэв таны цахим шуудангийн хаяг бүртгэгдээгүй байгаа бол “Цахим шуудангийн хаяг бүртгүүлэх” гэсэн товчийг дарна уу. Энд та өөрийн ашиглаж буй ямар ч цахим шуудангийн хаягийг Сиси систем дэх өөрийн мэдээлэлдээ нэмж бүртгүүлэх, МУИС-д харьяалагдах хаягийнхаа нууц үгийг солих боломжтой болно.

Анхаар: Бүртгүүлсэн хаягаар тань баталгаажуулах шуудан очих тул та тус хаягруугаа нэвтэрч чаддаг байх ёстойг анхаарна уу.

Цахим шуудангийн хаяг бүртгүүлэх

Энд та өөрт холбогдох дурын цахим шуудангийн хаягаа бүртгүүлэх боломжтой. Таны бүртгүүлсэн цахим шуудангийн хаягаар баталгаажуулах шуудан илгээнэ.

4. Бүртгүүлэх хаягаа бичээд “Илгээх” товчийг дарснаар тус хаягруу “Баталгаажуулах” шуудан илгээгднэ. Та шуудангаа шалгаж “Баталгаажуулах” товчийг дарснаар таны хаягийг бүртгэж авах болно.

Анхаар: Таны илгээсэн хүсэлт 24 цагийн хүчинтэй бөгөөд баталгаажуулаагүй 24 цаг өнгөрсөн тохиолдолд та дахин хүсэлт илгээх шаардлагатайг анхаарна уу.



МОНГОЛ УЛСЫН
ИХ СЭРГУУЛЬ

И-МЕЙЛ ХАЯГ НЭМЭХ ХҮСЭЛТИЙГ БАТАЛГААЖУУЛНА УУ.

Сайн байна уу. Та SISI системд b.oyunomin@gmail.com гэсэн хаягийг өөрт холбогдох хаягаар нэмэх хүсэлт гаргасан байна. "Батлах" сонгосноор таны и-мэйл хаягийг эцсийн байдлаар бүртгэж авах болно. Хэдий энэ хүсэлт нь 24 цаг хүчинтэй ч дахин системээр орж хүсэлт гаргах боломж таньд нээлттэй байгааг санаарай.

[Баталгаажуулах](#)

5. Хэрэв та өмнө нь МУИС-ийн цахим шуудангийн хаягийг ашиглаж байсан боловч нууц үгээ мартсан, ашиглахгүй удсан эсвэл шинээр анх үүсгэх хүсэлтэй байгаа бол “Цахим шуудангийн хаяг шинээр нээлгэх болон сэргээх” гэсэн товчийг дарна уу. Энд дарж хаяг сэргээх шинээр үүсгэх хүсэлт илгээснээр бид таны хүсэлтийг хүлээн авч, холбогдох мэдээллүүдийг шалган, хаягийг баталгаажуулах ба мэдээлэл зөрсөн тохиолдолд хүсэлтийг буцаах болно. Баталгаажуулсны дараа та шинэ нууц үг хийх боломжтой болно.

Анхаар: Таны мэдээллийг шалгаж хаягийг шинээр үүсгэх, сэргээхэд тодорхой хугацаа шаардагдахыг анхаарна уу.


Цахим шуудангийн хаяг шинээр нээлгэх болон сэргээх

Та энд дарж МУИС-ийн @num.edu.mn цахим шуудангийн хаяг шинээр нээлгэх болон өмнө нь ашиглаж байсан хаягаа сэргээх хүсэлт илгээнэ үү.

Цахим шуудангийн хаяг сэргээх

Хаягаа оруулна уу.

Хувийн шалтгаан



Хүсэлт илгээх

6. Танд энэхүү системтэй ажиллахад ямар нэгэн ойлгомжгүй, тодорхойгүй зүйл гарвал 1154 дотуур утасруу залгаж Мэдээллийн Технологийн Газарт хандана уу.